

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦЭРЭГЖСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ “НИЙТИЙН МОНГОЛ БӨХИЙН БАРИЛДААН”-Ы ТАЙЛАН

2019.01.23

Мандалговь хот

Дундговь аймгийн Биеийн тамир, спортын газар Аймгийн цагдаагийн газартай хамтран нийтийн Монгол бөхийн барилдааныг 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав. Тус тэмцээнд ОБГ, Цагдаагийн газар, Зэвсэгт хүчний 278-р байгууламж, тагнуулын хэлтэс ШШГГ, Шүүхийн шинжилгээний албаны хүчит 64 бөхийн барилдааныг хамтран зохион байгууллаа. Тус тэмцээнийг нээлтэнд аймгийн цагдаагын Хошууч. Аймгийн арслан Л.Баярсайхан, БТСГ-ын дарга наранбадрах нар оролцлоо. Тус тэмцээний

- Түрүүлсэн: Дэлгэрхангай сум дахь хэсгийн мөрдөн байцаагч А.Дэслэгч Д.Цогт-Очир
- Үзүүрлэсэн: эрүүгийн мөрдөн байцаагч: Дэслэгч Э.Бадмаанямбуу
- Шөвгөрсөн: ЗХ-278-р анги А/А Ц.Өнөрбат, Б.Тогтохшинэтөр нар шалгарлаа.

Тус барилдааны үеэр цэрэгжсэн байгууллагуудад алба хаадаг сумын цолтой бөхчүүдийн тойргын барилдаан зохион байгуулж тус барилдааны

- Тэргүүн байр: Цагаагын газрийн дэд ахлагч Б.Ууганбаяр
- Дэд байр : Цагдаагын газрийн Ахлах ахлагч Х.Энэбиш
- Гутгаар байр: Цагдаагийн газрын дэд ахлагч О.Бүрэнбат нар тус тус шалгарлаа.



БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА О.АМАРСАНАА

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА М.НАРАНБАДРАХ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦЭРЭГЖСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН
ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ "НИЙТИЙН МОНГОЛ"
БӨХИЙН БАРИЛДААНЫ УДИРДАМЖ

2019 оны 01 дүгээр сарын 20

Сайнцагаан сум

НЭГ: ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО

Уламжлалт сар шинийн баярыг угтаж цэрэгжсэн байгууллагуудын дунд алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг хөгжүүлэх, байгууллагуудын алба хаагч нарын нөхөрсөг харилцааг сайжруулах, үндэсний спортыг дээдлэх, сурталчилхад оршино.

ХОЁР: ХУГАЦАА

2019 оны 01 дүгээр сарын 23-нд 17 цагаас Дундговь аймгийн биеийн тамир спортын газрын зааланд зохион байгуулагдана.

ГУРАВ: ХАМРАХ ХҮРЭЭ

Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламж, Тагнуулын хэлтэс, Шүүхийн шинжилгээний албаны алба хаагчид хамрагдана.

ДӨРӨВ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийтийн Монгол бөхийн барилдаанд байгууллагуудаас оролцох тамирчдын доод хэмжээ нь Цагдаагийн газраас 32, Онцгой байдлын газраас 9, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас 9, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжаас 9, Тагнуулын хэлтсээс 3, Шүүхийн шинжилгээний албанаас 2 тамирчин оролцоно. Барилдааны 1, 2-ын давааг оноолтоор, 3 даваанаас эхлэн бөхчүүд сугалаагаар барилдаж түрүү, үзүүр, их шөвөгийн бөхчүүдийг шалгаруулна. Барилдах алба хаагчид зодог, шуудагтай барилдана.

ТАВ: ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Түрүү бөх Улаан бүс, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Үзүүр бөх шар бүс, мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, Их шөвөг Цэнхэр бүс, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал.

Жич: Сумын цолтой бөхчүүдийн барилдааныг тусд нь зохион байгуулан 1,2,3-р байр эзлүүлж медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС